

ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ҮЙЛДСЭН БОЛОН ХҮҮХЭД ХОХИРСОН ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ОНЦЛОГ

PECULIARITIES OF INVESTIGATING CASES COMMITTED BY JUVENILES AND CASES OF CHILD INJURY

Б.Батзаяа

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Өсвөр насны хүн хэдийгээр эрх зүйн этгээд мөн боловч биологийн хөгжил, ухамсар санаа, мэдлэг, оюун ухаан бүрэн төлөвшөөгүй, нийгмийн амьдрал, харилцаанд бие даан оролцох арга, чадвар, туршлага хараахан бий болоогүй буюу тэдгээр нь бүрэн бүрэлдээгүй зэрэг хүндэтгэн үзэх байдлууд нь тухайн этгээдийн статусыг онцлон үзэх жам ёсны гол үндэслэл болно.

Хүүхдийн эрхийг хамгаалах, өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тусгайлан авч үзэхийг дэмжин баталгаажуулсан олон улсын гэрээ, конвенцийн агуулга, энэхүү субъектын онцлог статусыг хүлээн зөвшөөрөх эрх зүйн үндэслэл, эрх ашгийг дээдлэх үзэл, хандлагын талаар дурдсан.

Abstract: Although a teenager is a legal person, his or her biological development, awareness, knowledge, and intelligence are not fully formed, and his / her ability and experience to participate in social life and relationships are not yet formed, or they are not fully formed, are the main natural grounds for emphasizing the status of the person, and an international agreement that promotes the protection of the rights of children and the criminal liability of minors, a number of conventions have been established to provide a legal basis for the recognition of this subject-specific status, respect for rights and attitude.

Түлхүүр үгс: Гэмт хэрэг, өсвөр насны хүн, хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал.

Keywords: crime, adolescent, children's rights, child protection.

Аливаа хэрэг, зөрчлийг шалгаж эхлэх үед гэмт үйл явдал ихэвчлэн болоод өнгөрсөн байдгаас түүнийг судлан шинжлэх, танин мэдэх, өнгөрсөн үйл явдлыг сэргээн тогтоох зорилгыг хангахад мөрдөн шалгах ажиллагаа бүхэлдээ чиглэгддэг¹³⁶. Мөрдөн шалгах анхан шатны ажиллагааны дарааллыг тогтооход гэмт хэргийн онцлог, гомдол мэдээллийг хүлээн авсан цаг хугацаа, мөрдөн шалгах ажиллагаа явагдах үеийн нөхцөл байдал онцгой үүрэгтэй.

Хүүхэд нь гэмт хэргийг бүлэглэн үйлддэг ба бүлэглэл нь тохиолдлын шинжтэй үүсч амархан тарж сарнидаг. Иймээс тэдний үйлдсэн гэмт хэрэг нь үргэлжилсэн үйлдэлтэй, үйлдэл бүрийн оролцогч нь солигдож байдаг. Энэ байдал нь тэдний өөр хоорондоо амархан танилцаж итгэлцдэгтэй холбоотой. Бүлэглэл нь байр хороолол, дүүргийн шинжтэй байдаг. Насанд хүрээгүй хүмүүс нь гэмт хэргийг баяжих зорилгоор үйлддэггүй цаг үеийн хэрэгцээ хангах, сонирхсон зүйлээ эзэмших, зарим тохиолдолд насанд хүрэгчдийн эрхшээл, дарамт шахалт ятгалгаар үйлддэг. Тэд бие биедээ зориг зүрхтэй харагдаж, бүлэг дотроо нөлөө бүхий гол хүн болох зорилгоор гэмт хэргийг үйлддэг¹³⁷.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны этгээдийн сэтгэл хөдлөл, оюун ухаан, сэтгэхүйн шинж, насны онцлог байдлаараа тусгай журам, үндэслэлд хамаардаг мөрдөн шалгах нэгэн онцлог ажиллагаа юм. Тиймд гэмт этгээдийн нас, сэтгэцийн болон амьдралын дадал, арга туршлагын хувьд нийгэмд бүрэн төлөвшилт олоогүй, эрх зүйн бүрэн чадамжгүй байдлыг нь харгалзан үзэж түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг нь хамгаалах нэмэлт баталгаа бий болгох, хууль дээдлэх, нийгмийн хэв журмыг хүндэтгэх үзэлд сургах, дахин гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдохоос

¹³⁶ Хууль сахиулах их сургууль. Гэмт хэрэг илрүүлэхүй. Сурах бичиг. УБ. 2015. 345 дахь тал.

¹³⁷ Хурцгэрэл Б. Криминалистик 2. Сурах бичиг. УБ. 2004. 539 дэх тал.


урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх, үлгэр жишээ зан төлөв олгох шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, насанд хүрээгүй, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч¹³⁸ нь өөрийн үйлдлийг ухамсарлах, хариуцах, мөрдөн шалгах ажиллагаанд заасан эрх, үүргийг бие даан хэрэгжүүлэх, өөрийгөө өмгөөлөх тал дээр дутмаг, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрхийг хамгаалах бодит шаардлага практикт тулгамдсан асуудал байдагтай холбоотой.

Гэмт хэргийн тоон үзүүлэлт

Цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хүнээс гэмт хэрэгт хохирсон, холбогдсон нөхцөл байдлыг судлахад цаг үеийн нөхцөл байдал, бүх нийтийн хорио цээрийн дэглэмийн үед насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн эзлэх хувь цөөнгүй бүртгэгдэж шалтгаан нөхцлийг судлахад хохирогчийн ураг төрлийн хамааралтай, ойр дотны хүмүүс үйлдэж бие махбодь, сэтгэл санааны хохиролд амь насаа хорлох, эцэг, эхчүүдээс хүүхдүүдийн тавих хараа хяналт сул байгаагаас өөрийн аюулгүй байдлаа хангаж чадахгүйд хүрч улмаар бэлгийн хүчирхийлэлд өртөх гэмт хэргийн хохирогч болж байна.

Насанд хүрээгүй хүний эсрэг 2022 онд 1967 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 48,8 хувь өсжээ. Бүх хэрэгт эзлэх хувийн жин 5.6 болж, мөн оны мөн үеэс 0.4 нэгжээр өссөн байна. Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн 1578 буюу 80.2 хувийг хөнгөн, 389 буюу 19.8 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 64.3 хувь нь Улаанбаатар хотод, 35.7 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.

График №1.



Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт мөн анхаарах зүйлс: Төлөвлөлт нь мөрдөн шалгах ажиллагааны үе шат болгонд зорилтыг, зохион байгуулалт нь түүнд хүрэх арга замыг тодорхойлдог бөгөөд төлөвлөлт нь бодитой, тодорхой, хэрэг, зөрчлийн онцлогт тохирсон, хөдөлгөөнтэй байх зарчмуудад тулгуурлана.¹³⁹ Төлөвлөлт нь үйл ажиллагааг дэс дараалалд оруулан цэгцэлдэг төдийгүй үр дүнг нэмэгдүүлж, хэргийг богино хугацаанд шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэг, материалд цугларсан материалыг судлах замаар системчлэх, шийдвэрлэх асуудлын хүрээг тодорхойлох, асуудлыг шийдвэрлэх арга замыг олох, шалгах гэсэн үе шаттай байдаг бол зохион байгуулалт нь хамтын ажиллагааг хангах, ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, мэдээлэл солилцох, ажлын ачаалал тэнцүүлэх, техник хангамжийг бүрдүүлэх, нууцлалыг хамгаалах зэрэг асуудлыг багтаана¹⁴⁰.

Өсвөр насны этгээд, хүүхдийн үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг тогтоох, нотлох ажиллагаанаас гадна, хуульд заасан нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай байдгаас мөрдөгч хэрэгт цугларсан материалыг судалснаар:

- Цугларсан мэдээлэл, баримтын аль нь нотлох баримт болох;
- Эд мөрийн баримтаар үйл явдлын аль хэсэг тогтоогдож болох;

¹³⁸ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2016. №7. 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан.

¹³⁹ Цагдаагийн албаны хамтын бүтээл. Криминалистикийн тактик. УБ. 2001. 14 дэх тал.

¹⁴⁰ Ганбаатар Г. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдсон гэмт хэргийг мөрдөх арга зүй. УБ. 2019. 55 дахь тал.

- Гэмт хэрэг, зөрчлийн аль хэсгийг гүйцээж нотлох;
- Нотлох баримтыг ашиглан шинээр ямар нотлох баримт гаргаж болох;
- Маргаантай асуудлыг хэдийд яаж шийдвэрлэх зэргийг тодорхойлсны үндсэн дээр хэрэг шалгах төлөвлөгөө боловсруулж, шалгах аргыг тусгана.

Өсвөр насны этгээд, хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн төлөвлөлт, зохион байгуулалт нь мөрдөгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, зохион байгуулалт¹⁴¹, ажлын арга барил, туршлага, шуурхай байдал, ёс зүйгээс ихээхэн шалтгаална. Эдгээр гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн аваад:

- Дуудлага, мэдээлэл өгсөн хүнээс мэдүүлэг авах;
- Хэргийн газрын үзлэг хийх;
- Тодорхой төрлийн эд зүйлсийг хураан авах /гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж, зэвсэг гэх мэт/;

- Гэмт хэрэг, зөрчлийг үйлдсэн этгээдийг түр саатуулах, эцэг эх, асран хамгаалагчийг дуудуулах /хүүхэд оролцсон ажиллагаа явуулахдаа тэдгээрийг өмгөөлөгчийн хамт оруулах/¹⁴²;

- Гэмт хэрэг, зөрчлийг үйлдсэн этгээдийн бие, эд зүйлд нь үзлэг хийх;
- Эд зүйл, мөнгө хүлээн авсан этгээдийг түр саатуулах, биед нь үзлэг хийх;
- Гэмт хэрэг, зөрчлийг нүдээр үзсэн эсвэл энэ талаар мэдэх этгээдүүдийг тогтоон, мэдүүлэг авах.

Өсвөр насны этгээд, хүүхэд холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг ямар нэгэн шалтаг, шалтгаанаар удаашруулалгүй, цаг алдалгүй явуулах, тухайн гэмт хэргийг бүрэн дүүрэн шалгах, бодит үнэнийг бүрэн дүүрэн, шуурхай тогтоох нь хэргийг эцэслэн шийдвэрлэх асуудал шалтгаалдаг тул хяналт тавьж байгаа дарга, ахлах нар энэ тал дээр анхаарч ажиллах шаардлагатай. Хэрэв гомдол мэдээллийг шалгах явцад гэмт этгээдийн нас тогтоох бололцоогүй бол энэ асуудлыг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шийдвэрлэнэ. Иргэний үнэмлэх буюу төрсний гэрчилгээ байхгүй тохиолдолд зохих бичиг баримт (эмнэлгийн дэвтэр, сурагчийн хувийн хэрэг, өрхийн бүртгэл гэх мэт) хурааж авах замаар насыг тодорхойлно. Энэ зорилгоор Иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас лавлагаа авч, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, хүүхдийн талаар сайн мэдэх хүмүүсээс гэрчээс мэдүүлэг авч болно. Бололцоо байхгүй бусад тохиолдолд шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэнэ.

Насанд хүрээгүй этгээдийн гэмт бүртгэлт, мөрдөн байцаалтыг төлөвлөхөд нотолбол зохих байдал (ЭХХШТХ-ийн 16.2)-аас гадна (ЭХХШТХ-ийн 18 дугаар бүлэг)-д заасан тусгай журмыг харгалзана. Өсвөр насны этгээд, хүүхэд холбогдсон хэргийг мөрдөн шалгахад бусад хэргээс цаг хугацаа их шаарддаг, явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаа нь хүч хөдөлмөр нэлээд шаарддагаараа онцлогтой. Энэ нь ихэнх гэмт хэрэг бүлэглэсэн шинжтэй, мөрдөн шалгах нэмэгдэл баталгааг хангах шаардлага, заавал байх оролцогч (эцэг, эх, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч гэх мэт)-ийг татан оролцуулах, насанд хүрээгүй этгээдийн амьдрал, хүмүүжлийн нөхцөлийг тогтоох шаардлагатай холбоотой.

ЭХХШТХ-иар өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлогийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох;
- Өсвөр насны яллагдагчийн үйлдсэн хэргийг тусгаарлах;
- Мөрдөн байцаалтад хууль ёсны төлөөлөгч оролцох;
- Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг дуудан ирүүлэх, баривчлах;
- Цагдан хорих;

¹⁴¹ Өсвөр насны этгээд, хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч оролцох шаардлага гардаг.

¹⁴² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №23. 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

- Өсвөр насны яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгчийг хавтаст хэргийн материалтай танилцуулах;

Өсвөр насны этгээд, хүүхэд холбогдсон хэрэгт тухайн этгээдийн амьдрал, хүмүүжлийн нөхцөлийг тогтоох ажиллагааг явуулдаг. Үүний тулд түүний гэр бүлийг тодорхойлох баримт цуглуулах ажиллагаа хийдэг. Үүнд:

- Эцэг, эх хоёул байгаа эсэх, хэн нэг нь байхгүй бол хэдийнээс, ямар шалтгаанаар байхгүй байгаа болох;

- Хэн түүнийг хүмүүжүүлж байгаа;

- Эцэг, эх, гэр бүл бүхэлдээ (ах, эгч, хамт амьдарч байгаа бусад хүмүүс) ямар байдалтай байдаг;

- Гэр бүл дотор ямар харилцаатай, ёс суртахууны буруу нөлөөлөл (архидан согтуурах, хэрэлдэх, зодолдох) байдаг эсэх;

- Амьдрал, ахуйн нөхцөл ямар болохыг харгалзах¹⁴³ шаардлагатай.

Өсвөр насны этгээд, хүүхэд ямар ч хяналтгүй байдаг байдал илэрвэл түүний шалтгааныг тогтооно (эцэг, эх зав чөлөөгүй байх, удаан хугацаагаар томилолтоор ажиллах, өвчлөх, хүүхдэдээ хайнга хандах, согтууруулах ундаа хэрэглэдэг гэх мэт).

Мөн өсвөр насны этгээд, хүүхэд ойрын хүрээлэн буй орчин их ач холбогдолтой байдаг тул дараах нөхцөл байдлыг тогтооно. Үүнд:

- Найз нөхөд, танил, тэдгээрийн харилцаа, насны байдал;

- Тэдний дунд урьд ял шийтгэгдсэн, ажил, сургуульгүй, ёс суртахууны доголдолтой этгээд байдаг эсэх;

- Тэдний дунд цахим тоглоомд уруу татдаг, согтууруулах ундаа хэрэглэх, мансуурахад татан оролцуулдаг эсэх гэх мэт.

Энэ болон бусад байдлыг тогтоосноор насанд хүрээгүй этгээдэд муугаар нөлөөлсөн, түүнчлэн гэмт хэрэгт хамтран оролцсон байж болох этгээдийг илрүүлнэ.

Өсвөр насны этгээд, хүүхэд нь суралцдаг бол сурлага, багш, нөхдөдөө хэрхэн ханддаг, түүний өдөр тутмын зан үйлийг тодруулна. Хэрэв насанд хүрээгүй этгээд суралцдаггүй байваас шалтгаан, хэдий хугацаагаар сургуулиа орхисон, түүнийг сургуульд буцааж оруулах ямар арга хэмжээ, хэн авсныг тогтооно.

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тэдний хүмүүжсэн орчин ахуйгаас нь юуны өмнө эрж, юуг хүндэлж, дуурайхыг эрмэлздэг болох, ажил сургуулиас гарсан бол хир удаж байгаа, ямар шалтгаанаар гарсан зэргийг тогтооно. Насанд хүрээгүй хүмүүс гол төлөв бусдын нөлөөгөөр болон өөрийн гэнэн томоогүй болгоомжгүйгээс гэмт хэрэг үйлдэх нь их байдаг. Эцэг, эх, багш, хүмүүжүүлэгчээс мэдүүлэг авч гэр бүл, ахуй, сургуулийн тухай баримт тогтооно.

Дээр дурдсан баримт цуглуулах явцад мөрдөгч насанд хүрээгүй этгээдийн зан ааш, сонирхол, шохоорхол, зуршил, чөлөөт цагаа өнгөрүүлдэг байдал, насны онцлог (мөрөөдөмтгий, итгэмтгий, зожиг зан)-ийг байнга анхаарч мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

Өсвөр насны этгээд болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг үйлдэх болсон болсон шалтгааныг тогтоох, гэмт санаа төрөхөд хүргэсэн, гэмт хэрэгт бэлтгэх, үйлдэх, нуухад дэмжлэг болсон байдлыг илрүүлэх зайлшгүй шаардлагатай.

Хэргийн газрын үзлэг хийх. Өсвөр насны этгээд болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэгт учрал болсон газарт хийх үзлэг хийх ажиллагаа нь тухайн гэмт хэргийг насанд хүрээгүй этгээд үйлдсэн болох таамаглал дэвшүүлэх, нотлох баримтыг илрүүлэх, нөхөн гүйцэтгэх боломжгүй ажиллагаа юм.

Үзлэгийг ердийн журам, тактик, дарааллын дагуу явуулах бөгөөд өсвөр насны этгээд болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэгт үйлдлийн арга нь дараах байдлаараа онцлогтой байдаг. Үүнд:

1. Чиглэсэн зорилгогүй, урьдаас төлөвлөж, хэрэгжүүлсэн үйлдэлгүй байх. Жишээлбэл, орон байранд эхлээд нэг, дараа нь өөр замаар нэвтрэх оролдлогын мөр

¹⁴³ Хурцгэрэл Б. Криминалистик 2. Сурах бичиг. УБ. 2004. 542 дахь тал.

байх; эмх замбараагүй байх, үйлдлээ дуусгаагүй байх, ноцтой арга хэрэглээгүй байх болхи, заль мэхгүй аргаар нэвтрэх, жишээлбэл, цонх хагалах, их хүч хэрэглэхгүй биеийн хүчээр эвдэх, түгжих төхөөрөмжийг эвдэхэд энгийн арга ашиглах, бага хэмжээний цонх болон цонхны торны завсраар нэвтэрсэн байх гэх мэт;

2. Гэмт хэргийн мөр нуух арга хэмжээ аваагүй байх;

3. Гэмт хэргийн газар ичгүүргүй, дүрсгүйтсэн үйлдэл хийсэн байх (бараа гэмтээх, эд зүйлийг ямар ч шалтгаангүйгээр эвдэх, зохисгүй бичлэг, зураг үйлдэх).

Өсвөр насны этгээд болон хүүхдээс үйлдсэн хулгайлах гэмт хэргийн халдлагын зүйл онцлогтой:

- магнитофон, дүрс бичлэг- гэрэл зургийн техник, спортын бараа, цаг;

- чамин хувцас, гутал, куртка, цүнх;

- мөнгө, үнэт зүйлс;

- амтат зүйл, ундаа, хүнсний бүтээгдэхүүн. Хэргийн газарт үнэ хүрч болох зүйлийг авалгүй, бусад зүйлд анхаарлаа хандуулсан байх (үнэт үслэг эдлэл, хуучны ховор зүйл гэх мэт).

- хэмжээгээр жижиг хөл, гарын мөр;

- өсвөр насныхны өмсдөг ердийн гутлын улны дардас (өсвөр насныхны дэгжин гутал, пүүз);

- насны бүлгийг тодорхойлж болох орхисон, хаясан, гээсэн хувийн эд юмс;

- цөөн биш насанд хүрээгүй этгээд авч явдаг эд зүйл: гар хийцийн хүйтэн зэвсэг, гинж, төмөрлөг гоёл;

- хүнсний зүйл дээрх шүдний мөр гэх мэт¹⁴⁴.

- Учрал болсон газар үзлэг хийх явцад насанд хүрээгүй гэмт хэрэгтний хувийн шинжийн тухай мэдээлэл олж авч болно. Учрал болсон газар байгаа объект, боодол, шил, тамхины иш гэх мэт буюу хулгайлсан эд зүйлийн шинжээр зуршил (тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх, мансуурах)-ын тухай дүгнэлт хийж болно.

Хүнийг алах, хүчиндэх, дээрэмдэх, танхайрах гэмт хэргийн газарт насанд хүрээгүй хүмүүсийн онцлог шинж тэмдэг нь тэдний зүгээс гаргасан харгис хэрцгий авир увайгүй байдлаар илэрнэ¹⁴⁵.

Хүний биед үзлэг хийх. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, хүүхдийн үйлдсэн, хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирогчид учирсан гэмтэл шарх учрах нь харьцангуй ойлголт бөгөөд ихэнх тохиолдолд богино хугацаанд устаж үгүй болох ул мөр улайлт, хөхрөлт үүссэн байдаг. Тиймээс эдгээр ул мөрийг илрүүлэх, бэхжүүлэн авахын тулд хохирогчийн биед үзлэг хийх зайлшгүй шаардлагатай.

Хүний биед хийх үзлэг нь энгийн нүдээр сэжигтэн, яллагдагч, хохирогчийн биед гэмт хэрэг, зөрчлийн ул мөр болох шарх, сорви байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор мөрдөгчөөс явуулдаг ажиллагаа юм. Тиймээс мөрдөгчийн хүний биед хийх үзлэг нь шинжээч эмчийн үзлэгээс ялгаатай байна. Энэхүү үзлэг нь нэг талаас хүчирхийллийн улмаас хохирогчийн биед хүч хэрэглэсэн эсэх болон гэмтэл учирсан эсэхийг тогтоох, нөгөө талаасаа шүүх эмнэлгийн шинжилгээ томилох үндэслэлийг тодорхойлох урьдчилсан нөхцөл болдог. Үзлэг хийлгэж буй хүний бие дээр ямар нэг шарх, сорви байвал шинэ хуучин гэж ялгалгүйгээр тэдгээрийг биеийн аль хэсэгт байгаа, хоорондын зай, хэмжээ, хэлбэр, тоо ширхэг, өнгө зүс зэргийг нэг бүрчлэн үзэхийн хамт фото болон дүрс бичлэг, тэмдэглэлээр бэхжүүлж авна.

Гар утсанд үзлэг хийх. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, хүүхдийн үйлдсэн, хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлийг үйлдсэн этгээд, тэдгээрийн хууль бус үйлдлийг бэхжүүлсэн, эсвэл тухайн үйлдэгдсэн хэрэг, зөрчлийн талаар хоорондоо харилцсан, хэн нэгэн хэнд хүнд хандаж болсон зүйлийн талаар хэлсэн үйлдлийг бэхжүүлэхээр гар утаст үзлэг хийж болно. Үзлэгийг мөрдөгч дангаар болон мэргэжилтний хамт хийж болно. Гар утаст хийх үзлэгийг:

¹⁴⁴ Хурцгэрэл Б. Криминалистик 2. Сурах бичиг. УБ. 2004. 548 дахь тал.

¹⁴⁵ Болдбаатар Ж. Криминалистик тактик. УБ. 2001. 301 дэх тал.

- Гадна хэсэгт хийх үзлэг,
- Гар утаст хадгалагдаж байгаа мэдээлэлд хийх үзлэг гэж хоёр ангилна.

Гадна хэсэгт хийх үзлэгээр гар утасны гадаад байдал, өнгө, загвар, модель /илт тодорхой байвал/, сериал дугаар, IMEI код зэргийг тусган, сим карт, мемори карт, түүний хэлбэр хэмжээ, дугаар зэрэгт үзлэг хийн, гэрэл зургаар бэхжүүлнэ. Хадгалагдаж байгаа мэдээлэлд хийх үзлэгээр гар утсыг хамгийн түрүүнд online mode төлөвт шилжүүлнэ. Уг үзлэгээр доорх төрлийн мэдээллүүдэд нарийвчлан үзлэг хийнэ. Үүнд:

- Хүлээн авсан, залгасан дуудлага хэсэг;
- Хүлээн авсан, илгээсэн мессеж хэсэг;
- Фото зураг, бичлэг хэсэг;
- Дуу хураагуур хэсэг;
- Хадгалагдсан дугаар хэсэг;
- Календарь хэсэг, түүнд хийсэн тэмдэглэлүүдэд хэсэг;
- Е-мэйл болон бусад Facebook, Whatsapp, Viber, Skype зэрэг харилцаа холбооны аппликейшин хэсэг;
- Мультимедиа зурвас, видео зурвас хэсэг;
- Интернет хөтчүүдийн түүх хэсэг;
- Байршил тогтоогч хэсэг;
- Бусад баримт бичиг хэсгийн хавтаснуудад дэд хэсэг болгон үзлэг хийж ач холбогдол бүхий мэдээллийг гэрэл зураг, дүрс бичлэгээр давхар бэхжүүлэн үзлэг хийнэ.

Шаардлагатай бол мэргэжилтний туслалцаатай гар утас дахь бүхий л мэдээллийг хуулбарлан авч, нарийвчилсан шинжилгээ хийхээр зориулалтын уут саванд /эсвэл соронзон долгио үүсэхгүй гялгар уут гэх мэт/ хийн битүүмжлэн холбогдох байгууллагад хүргүүлнэ¹⁴⁶.

Баривчлах, цагдан хорих. Өсвөр насны яллагдагчийг (ЭХХШТХ-ийн 18.8) цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгч, эсхүл хүсэлт гаргасан хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулах бөгөөд, түүнийг цагдан хорих ердийн журмаас гадна урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

Үйлдсэн гэмт хэргийн шинж, түүний хувийн байдлын онцлог, гэмт хэрэг үйлдсэний дараах үйлдэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсхийх санаа, боломжийг мөн харгалзах хэрэгтэй. Гэмт үйлдлийн хэрцгий байдал, санаа бодлын хандлага, гэмт үйлдлийг бодож боловсруулсан байдал, гэмт хэрэг дахин үйлдэх эсэх, эрүүгийн орчинтой холбоотой эсэхийг мөн анхаарвал зохино¹⁴⁷. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг баривчлах, саатуулах ажиллагаанд бэлтгэх, тухайн ажиллагааг явуулахдаа өдрийн цагаар, бусдын анхаарал татахгүй явуулна (сургууль, клуб, дугуйлан дээрээ, найз нөхөд, анги хамт олны дунд байхад баривчилж болохгүй). Мөн эсэргүүцэл үзүүлэх, зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах боломжийг харгалзан, эрсдэлийг тооцон явуулах хэрэгтэй. Ямар учраас баривчлагдаж, цагдан хоригдох болсон болон хуульд заасан эрхийг түүнд тайлбарлаж өгнө. Баривчлагдсан, цагдан хоригдсон, одоо хаана байгаа тухай эцэг, эх (хууль ёсны төлөөлөгч)-д 2 цагийн дотор мэдэгдэнэ.

Мэдүүлэг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хамгийн түгээмэл явагддаг, нотлох баримтаар үнэлэгддэг ажиллагаа бол мэдүүлэг авах ажиллагаа юм.

Өсвөр насны этгээдээс мэдүүлэг авахдаа тэдний сэтгэхүйн болон насны онцлогийг зайлшгүй тооцох шаардлагатай юм. Тиймээс тэдний мэдүүлгийн бодит байдлыг хангах үүднээс эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, өмгөөлөгч,

¹⁴⁶ Хурцгэрэл Ж., Эрдэнэбат Б. Сонгуулийн үед ажиллах цагдаагийн алба хаагчийн үүрэг гүцэтгэх үеийн тактик, арга зүй, аюулгүй ажиллагаа. УБ. 2020. 225 дахь тал

¹⁴⁷ Хурцгэрэл Б. Криминалистик 2. Сурах бичиг. УБ. 2004. 550 дахь тал

сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг байлцуулах тухай процессын нэмэлт баталгаануудыг хуульчилсан байдаг.

Насанд хүрээгүй хүмүүсийг байцаахад сэтгэл зүйн холбоо тогтоох явдал маш чухал. Хүүхдийн сэтгэхүйн онцлогийг бүрэн мэдэхгүй байх нь мөрдөгч, хүүхэд хоёрын хоорондын холбоог алдагдуулахад хүрнэ. Сурган зүй болон сэтгэл зүйн шинжлэх ухаанд насанд хүрээгүй хүмүүсийг тэдний физиологийн болон сэтгэхүйн хөгжлийн онцлогийг харгалзан таван бүлэгт ангилсан байдаг. Эдгээр нь:

- 1-3 нас балчир нас;
- 3-7 нас сургуулийн өмнөх нас;
- 7-11 нас бага нас;
- 11-14 нас өсвөр нас;
- 15-18 нас ахлах насныхан гэж ангилдаг ба насны онцлогийг харгалзан

тэднээс асуух асуулт, мэдүүлгийн тактикаа боловсруулдаг.

Ахлах нас буюу процессын хуульд зааснаар 15-18 нас хүртэлх өсвөр насныхны хувьд хямралт үе буюу хувь хүн болон төлөвших үе, эсхүл шилжилтийн нас ч гэж нэрлэдэг насан дээрээ яваа онцлогтой. Энэ насанд тэдэнд ертөнцийг харах өөрийн үзэл бүрэлдэн, бие даах хэрэгцээ шаардлага нь эцэг, эх, багш нарын хараа хяналтаас гарах гэсэн эрмэлзлээр илэрч байдаг¹⁴⁸. Тэдний сэтгэл зүйн онцлог нь хараат бус, бие даасан байдлыг хүсэх, өөрийн боломж чадварыг хэтрүүлэн үнэлэх, зан төлөвийн хувьд идэвхтэй, хөдөлгөөнтэй, сэтгэлийн хөөрөл ихтэй байдаг төдийгүй, сэтгэл санааны байдал амархан өөрчлөгддөг. Гэсэн ч энэ насанд ертөнцийг үзэх үзэл, зан чанар нь бүрэн бүрэлдэн төлөвшөөгүй байдаг. Өсвөр насны этгээдийг мэдүүлэг өгч байх хооронд асуулт тавьж болохгүй. Учир нь тэд ярих гэж байсан зүйлээ мартах зэргээр мэдүүлгийн бүрэн дүүрэн байдалд нөлөөлнө. Харин тэднийг анхааралтай сонсвол тухайн болж өнгөрсөн үйл явдлаар зогсохгүй мөрдөгчийн мэдэхгүй хүчирхийллийн өөр хэргийг ч мэдүүлдэг. Харин үйлдсэн гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хохирогч сэтгэл зүйн хямралд хүчтэй орсон байвал мэдүүлгийг хойшлуулах, эсхүл хэсэг хугацааны дараа дахин мэдүүлэг авах нь зүйтэй.

Хууль ёсны төлөөлөгчдийн зүгээс үзүүлэх нөлөөллийг хязгаарлахын тулд Эрүүгийн процессийн хуульд сурган хүмүүжүүлэгч, өмгөөлөгч, улсын яллагч зэрэг мэргэжилтэн оролцуулж болохыг хуульчилсан байдаг. Практикт эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч нь хүүхдэд туслахаасаа илүү бодит байдлыг гуйвуулах, өөрсдөө үлгэргүй байдал гаргах, хүүхдийг айлган сүрдүүлэх зэргээр тэдэнд хохирол учруулах тохиолдол гардаг¹⁴⁹ болохыг анхаарвал зохино.

Хүүхдийг байцаахад хууль ёсны төлөөлөгч болох эцэг эх нь зайлшгүй байлцах шаардлагатай байдаг ч өсвөр, ахлах насныхныг байцаахад тэднийг байлцуулах эсэхийг онцгойлон анхаарч хүүхдийн өгөх мэдүүлэгт нөлөөлж байна гэж үзэх үндэслэл байвал эрх бүхий хөндлөнгийн оролцогчдыг байлцуулах нь үр дүнтэй. Дээрх мэргэжилтнүүд мөрдөгчийг бүрэн дүүрэн мэдүүлэг авахад туслах үүрэгтэй. Энэ тохиолдолд мэдүүлгийн өмнө тэднийг тухайн ажиллагаанд ямар үүрэгтэй оролцож байгааг болон биеэ хэрхэн авч явах талаар ойлгуулах нь чухал. Ийнхүү тэдний байр суурийг нь тайлбарлан ойлгуулаагүйгээс зарим оролцогч мэдүүлэг авах мэргэжлийн бэлтгэлгүй мөртөө санаачилгыг өөртөө авснаар тухайн ажиллагааг тасалдуулах нь бий.

Хөвгүүд эрэгтэй сурган хүмүүжүүлэгчтэй мэдүүлэг өгөхийг чухалчилдаг бол, охид эмэгтэй сурган хүмүүжүүлэгчтэй мэдүүлэгт оролцохыг илүүд үздэг. Боломжтой бол өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас саналыг асуух нь чухал. Тэдний саналыг асуулгүйгээр мэдүүлэг авах ажиллагаанд оруулсан сурган хүмүүжүүлэгч нь таарамжгүй харьцаатай эсхүл айдаг сурган хүмүүжүүлэгч нь бол тэд мэдүүлэг өгөхгүй дуугаа хураан суух болно. Мөн насанд хүрээгүй хүмүүсээс мэдүүлэг авахын өмнө

¹⁴⁸ Эрдэнэбат Б. Өсвөр насны этгээдийн холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлог. Цагдаа судлал сэтгүүл. 2019. 2 дахь тал

¹⁴⁹ Бүжинлхам Ц. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Тусгай анги. УБ. 2007. 194 дэх тал

сонирхдог зүйл, найз нөхөд сургууль багшийнх нь талаар ярилцан түүний мэдүүлэг өгөхөд бэлтгэсэн хариултын дарааллыг алдагдуулах, мөн тодруулах асуулт тавихдаа дараалалгүй байдлаар насны онцлогт тохируулан тавьж, хариулт авах нь бодитой мэдүүлэг авах үндэс болдог.

Өсвөр насны сэжигтнээс мэдүүлэг авах. Насанд хүрээгүй сэжигтнээс мэдүүлэг авах нь ажиллагааг баривчилсны дараа шууд явуулах нь үр дүнтэй ч тухайн ажиллагаанд оролцогчдыг урьдчилан бэлтгэсэн байвал зохино. Мөрдөгч тухайн шатанд гэмт хэрэг үйлдэхэд оролцсон сэдэлт, гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн тухай хангалттай нотлох баримт, хувийн байдлын талаар зохих ойлголтыг, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдагт өсвөр насны этгээдээс мэдүүлэг авах бэлтгэлийн өвөрмөц онцлог оршино. Гэлээ ч гэсэн энэ нөхцөлд эцэг, эх, багш, хөршөөс мэдүүлэг авч, насанд хүрээгүй этгээдийн тухай бага ч гэсэн мэдээлэл цуглуулах хэрэгтэй. Мэдүүлэг авах ажиллагааг хойшлуулшгүй явуулснаар тухайн этгээдийг ятгаж болзошгүй насанд хүрсэн этгээдтэй холбоо бариулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Мэдүүлэг авах цаг, тактикийг сонгож авахдаа өсвөр насны этгээдийн сэтгэл зүйн байдлыг харгалзах хэрэгтэй. Энэ нь жирийн биш байдлаас урган гарсан зовиуртай хосолсон сэтгэл хөдлөл байна. Ял шийтгэгдэх, эцэг, эх, илчлэгдэхээс айдаг тул мэдүүлэг авах ажиллагаа ямар чухал болох, мөрдөгчтэй хамтран ажиллавал зохистойг ойлгуулах шаардлагатай. Анхны мэдүүлгийн явцад объектив, бүрэн дүүрэн авч чадсан анхны мэдүүлэг үндсэн, шийдвэрлэх шинжтэй байна. Амьдрал, сургууль, хүмүүжил, сонирхлын тухай яриагаар мэдүүлэг авах ажиллагааг эхэлбэл зохино. Үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоогүй гэж бодож, насанд хүрээгүй этгээд өөрийн болон найз нөхдийн тухай дуртайяа ярьж болно. Биеийн намтрын талаар сайтар ярилцсаны дараа ямар гэмт хэрэгт тэрээр сэжиглэгдэж байгааг дэлгэрэнгүй, ойлгомжтойгоор тайлбарлана. Үүний дараа баривчлах, цагдан хорих буюу таслан сэргийлэх бусад арга хэмжээ авах үндэслэл болсон байдлын талаар мэдүүлэг өгөх бололцоог түүнд олгоно.

Асуулт зөв тавих их чухал. Асуулт товч тодорхой, санаа авхуулах бодит баримт агуулаагүй байх ёстой. Ятгагдах гэдэг түүний онцлог шинжийг мартаж болохгүй. Өсвөр насны сэжигтэн ятгагдах, хөгжөөгүй логик сэтгэхүйн улмаас өөрийгөө гүтгэх, мөрдөгчийн тавьсан асуултаас онцлон авсан мэдээллийг ашиглан өөрийгөө гэм буруутай юм байна гэж үзэх тал байдаг. Мэдүүлэг авах үед мөрдөгч үйлдэгдсэн гэмт хэргийн байдлыг мэдэж байгаагаа харуулах бас чухал. Гэхдээ энэ нь учрал болсон газар хийсэн үзлэгийн тэмдэглэл, харсан хүний мэдүүлэг гэх мэт жинхэнэ мэдээллээс үүсэлтэй байх ёстой. Бага ч гэсэн үнэмшилтэй нотлох баримт сэжигтэнд үзүүлэх гэнэт байх хүчин зүйлийг ашиглах нь үнэн зөв мэдүүлэг өгөхөд чухал нөлөө үзүүлнэ. Мөн тухайн этгээдэд аль нэг нотлох баримт үзүүлэхдээ өөрийн нас, хөгжлийн улмаас түүний үнэ цэнийг бүрэн үнэлж чаддаггүй тул үзүүлж байгаа бодит баримтын жинхэнэ ач холбогдлыг түүнд тайлбарлана.

“Алиби¹⁵⁰” зааж байгаа насанд хүрээгүй этгээд түүнд урьдаас бэлтгэдэггүй тул газар, цаг, гэрч, хамтарсан үйлдлийн тухай нарийвчилсан асуулт, түүнд өгсөн хариу, мэдүүлгийн тэмдэглэлд бэхжүүлсэн мэдээлэл түүний “Алиби” үндэслэлгүйг илрүүлдэг тул дэлгэрэнгүй мэдүүлэг авах замаар үгүйсгэнэ.

Өсвөр насны, тэр дундаа 14-16 настай этгээдүүдээс мэдүүлэг авахад сурган хүмүүжүүлэгч оролцож болох боловч олон хүчин зүйлийг ямагт харгалзан энэ асуудлыг шийдвэрлэвэл зохино. Тодруулбал, гэмт хэргийн шинж, түүнийг үйлдэхэд сэжигтний гүйцэтгэсэн үүрэг, насанд хүрээгүй этгээдийн хувийн чанар зэрэг бусад олон хүчин зүйл.

Өсвөр насны яллагдагчаас мэдүүлэг авах. Ял сонсгоход мөрдөгч өсвөр насны этгээдийн тухай шаардлагатай бүхий л мэдээллийг хавтаст хэрэгт хавсаргасан байх ёстой. Ингэснээр мөрдөгч түүний ёс суртахуун-сэтгэл зүй, нийгэм-хүн ам зүйн шинжийг мэдэж чадна. Энэ үед өсвөр насны этгээдийн байр суурь тодорхой болсон байх учир

¹⁵⁰ “Алиби” гэж гэмт хэрэг үйлдэгдэж байх цаг хугацаанд сэжиглэж буй этгээдийг өөр газар байсныг тогтоосон нотлох баримтыг хэлнэ.

мэдүүлэг эхлэхээс өмнө өсвөр насны этгээдийн сэтгэл зүйн шинжийг сурган хүмүүжүүлэгч, өмгөөлөгчид танилцуулж болно. Эцэг, эхийн тухайд гэвэл сэжигтний нэгэн адил яллагдагчийг мэдүүлэг авахад тэднийг оролцуулахгүй байх нь зүйтэй.

Мэдүүлэг авах ажиллагаанд оролцогчоос асуулт тавих журам, үг зөрөлдөх, сөрөг үг хэлэх, өсвөр насны этгээдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх санал, үзэл бодол илэрхийлэхгүй байхад онцгой анхаарах хэрэгтэй. Мэдүүлэг авах ажиллагааны өмнө насанд хүрээгүй этгээдийг яллагдагчаар татсан тухай тогтоол уншиж сонгоно. Үүний дараа сонсгосон ялын гол утга, эрүүгийн хэргийн зүйлчлэлийн үндэслэл, тогтоолд дурдсан мэдүүлэг авах шийтгэх хэм хэмжээ, эрх, гэм бурууг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг ойлгомжтой хэлбэрээр тайлбарлана.

Мөрдөгч мэдүүлэг авах ажиллагааны эхэнд сонсгосон ялд өөрийгөө гэмт буруутайгаа хүлээж байгаа эсэхийг тодруулна. Нотлох баримтын нөлөөгөөр насанд хүрээгүй этгээд байцаалтын явцад өөрийн байр сууриа өөрчилж болох учраас үгүйсгэсэн хариуг тэр даруйд нь бэхжүүлэх хэрэггүй.

Өсвөр насны этгээд өөрийн гэм бурууг хүлээсэн ч мэдүүлэг авах ажиллагааг яаралгүйгээр, дэлгэрэнгүй, нарийвчлан явуулна. Гэмт хэргийн байдал, оролцогч бүрийн үүргийг дээд зэргээр нарийвчлах нь чухал. Үүний тулд гэмт хэргийн өмнөх байдал, оролцогч бүрийн үйлдэл, хэн санаачилсан, үүргийг анх яаж хуваарилсан, ямар бэлтгэл ажиллагаа хийгдсэн зэргийг илрүүлнэ. Тэгэхдээ гэмт хэрэгт бэлтгэх шатанд насанд хүрээгүй этгээдийг татан оролцуулах, ууж согтуурах, биеэ үнэлэхэд хүргэх үйлдэл хийгдсэн эсэхийг анхаарах хэрэгтэй. Гэмт хэргийн үйлдлийн аргыг тодруулахдаа гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, арга, оролцогч бүрийн үйлдэл, энэ үйлдлийн дараалалд хамаарах мэдүүлгийг нарийвчлан авах хэрэгтэй. Хэрэв насанд хүрээгүй этгээд гэм буруугаа хүлээхдээ нарийвчлалд төөрөлдсөн байвал энэ нь сэтгэц-биеийн шинж (сэтгэлийн хөөрөл, дутуу хөгжил гэх мэт)-ийн улмаас болж байна уу, эсхүл тэр өөр эх үүсвэрээс мэдэх болсон мэдээллийг өгүүлж байна уу гэдгийг онцгойлон ялгавал зохино. Мөн мэдүүлэг авахдаа гэмт хэргийн дараа насанд хүрээгүй этгээд, түүний хамтрагч биеэ хэрхэн авч явсан, ямар үйлдэл хийсэн, насанд хүрэгчдээс хэн холбоонд орсон, ямар зорилгоор (хулгайлсан эд зүйл борлуулах, нуух гэх мэт) зэргийг тогтоох нь чухал. Насанд хүрсэн хатгагч буюу бусад оролцогчийн үүргийг тогтоохын чухлыг бүх мэдүүлэг авах ажиллагааны туршид санаж байх хэрэгтэй. Үүний тулд өсвөр насны этгээдийн чөлөөт өгүүллийн байдлыг ихэд анхааралтай сонсож, насанд хүрсэн болон өсвөр насны этгээд хоорондын харилцаа, хамтарсан үйлдэлд хамаарах урьдчилан бэлтгэсэн асуултыг мэдүүлгийн явцад тавина.

Нүүрэлдүүлэн мэдүүлэг авах. Насанд хүрээгүй этгээдийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нүүрэлдүүлэн мэдүүлэг авахад ихээхэн болгоомжтой хандах хэрэгтэй ба зөвхөн онцгой тохиолдолд энэ ажиллагааг явуулна. Нүүрэлдүүлсэн мэдүүлэг авах ажиллагаанд насанд хүрээгүй этгээд нэртэй болох, өшөө авахаас айдаг тул дурамжхан ханддаг. Нүүрэлдүүлэн мэдүүлэг авах нь мөрдөгч, насанд хүрээгүй этгээд хооронд тогтсон сэтгэл зүйн холбоог бүрэн эвдэнэ. Нөгөө оролцогч, ялангуяа энэ тал нь гэмт хэргийн насанд хүрсэн оролцогч бол түүний нөлөөгөөр өөрийн мэдүүлгээ өөрчилж болзошгүйд гол аюул оршино. Насанд хүрсэн этгээд нүүрэлдүүлэн мэдүүлэг авсны дараа ч өөрийн гэмт буруугаа үгүйсгэж байгаа нөхцөлд насанд хүрээгүй этгээд заримдаа маш хүнд байдалд орно. Энэ байдал насанд хүрээгүй этгээдийн байр суурийг туйлбаргүй болгож, насанд хүрсэн этгээдийн зүгээс ямар нэг илэрхий заналхийлэл байхгүй байсан ч өөрийн мэдүүлгээ өөрчлөхөд хүргэдэг.

Насанд хүрээгүй этгээдүүдийг хооронд нь нүүрэлдүүлэн мэдүүлэг авах илүү төвөгтэй. Насан хүрээгүй этгээдүүд тэдний хоорондын зохисгүй харилцаанаас болж, мэдүүлэг зөрүүтэй байгаа гэж тайлбарлах тохиолдол их байдаг. Нүүрэлдүүлэн мэдүүлэг авахгүйгээр насанд хүрээгүй яллагдагч, бусад оролцогчийн мэдүүлгийн зөрүүг арилгах бололцоотой бол мөрдөгч түүнийг ашиглах хэрэгтэй. Цуглуулсан нотлох баримтад шинжилгээ, дүгнэлт хийх, шаардлагатай бичиг баримтыг шаардаж

авах, мэдүүлэг авахаас бусад ажиллагаа (мөрдөн байцаалтын туршилт, мэдүүлгийг газар дээр нь шалгах гэх мэт) явуулж энэ зөрүүг арилгана. Насанд хүрээгүй яллагдагч, гэрчийн мэдүүлгийн бичлэгийг сонсгож, мэдүүлэг нь зөрүүтэй байгаа талаар тодруулж болно.

Шинжээч томилох. Үйлдэгдсэн гэмт хэргийн шинжээс шалтгаалан шүүх эмнэлэг, шүүх сэтгэгц эмгэг судлалын, сэтгэгц судлалын шинжээч хийлгэх нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах онцлог болдог.

Нас тогтоох шүүх эмнэлгийн шинжилгээ. Насанд хүрээгүй этгээдийн насыг гэрчлэх бичиг баримт байхгүй, насаа санаатайгаар нуух, байгаа бичиг баримт эргэлзээ төрүүлж байвал шүүх эмнэлгийн шинжээч заавал хийлгэнэ. Шүүх эмнэлгийн шинжээч бие организм, насны өөрчлөлтийн тухай шинжлэх ухааны үндэстэй биеийн бүтэц, ерөнхий хөгжил, нуруу (өндөр, нам) ба биеийн жингийн үзүүлэлт, араг ясны бэхжилт, шүдний хөгжил гэх мэтийг үндэслэн насыг ойролцоогоор тогтооно. Тухайн шинжилгээгээр дараах байдлыг тогтооно. Үүнд:

- О-ийн биологийн нас хэд бэ?

- мэдүүлэгт дурдсан 12 насанд хүрсэн эсэх?¹⁵¹

Насанд хүрээгүй этгээдийн сэтгэцийн байдлыг тогтооход шүүх сэтгэгц, эмгэг судлалын шинжилгээ хийлгэнэ. Архаг өвчин, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааны түр зуурын саатал, ухааны доройтол буюу бусад өвчний улмаас насанд хүрээгүй этгээдийн сэтгэгцэд хомсдол үүсдэг.

Сэтгэгц эмгэг судлалын шинжилгээ. Оюуны ухааны хомсдолыг тогтоохын тулд шүүх сэтгэгц эмгэг судлалын шинжилгээ хийлгэнэ. Тухайн сэтгэгц, эмгэг судлалын шинжилгээгээр ердийн асуултаас гадна:

- Насанд хүрээгүй этгээдийн оюун ухааны хөгжил ямар зэрэгтэй болох?

- Насанд хүрээгүй этгээдийн оюун ухааны хөгжил нь тухайн насанд байх хэвийн түвшинөөс гажсан шинж байгаа эсэх?

- Хэрэв гажсан бол тухайн гажиг юунаас үүссэн болох? Ямар нэгэн сэтгэцийн өвчний улмаас бий болсон эсэх?

- Бие, сэтгэцийн байдлаараа насанд хүрээгүй этгээд байдлыг зөвөөр тусгаж, тухай зөв мэдүүлэг өгч чадах эсэх;

- Өөрийн болон түүний эсрэг үйлдлийг насанд хүрээгүй этгээд бүрэн ухамсарлаж чадах эсэх;

- Насанд хүрээгүй этгээд өөрийн үйлдлийг жолоодож чадах эсэх? Хэрэв чадах бол ямар хэмжээгээр жолоодож чадах болох?

Хавтаст хэргийн материалтай танилцуулах. Мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг танилцуулна. Тухайн ажиллагааг явуулахдаа өсвөр насны яллагдагчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна. Хэрэв тухайн яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл мөрдөгч нь өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй байж болно.

Хавтаст хэргийн материалтай танилцахдаа мөрдөгчөөс тогтоосон хугацаанд танилцах ба хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцаж, тодорхой баримтыг хуулбарлан авч болно.

Дүгнэлт

Эмзэг бүлгийн болон гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, хүүхэд хамгааллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй хэлтэс, Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан,

¹⁵¹ Эрдэнэбат Б. Мөрдөгчийн гарын авлага. УБ. 2019. 295 дахь тал.

хүүхдийн байцаагч нартай хамтран, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан цахим хөтөлбөрүүдийг боловсруулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнхи нь урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна. Мөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэл санааны хохирлоо хэрхэн барагдуулах, түүнийг тооцох аргачлал тодорхой бус байгаа, мөн эрүүгийн болон иргэний шүүхээр олон шат дамжлага дамжиж явах нь тэднийг хохирлоо бүрэн барагдуулахад хүндрэл бэрхшээлтэй байгааг дурдах нь зүйтэй.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхдийн асуудлаар “Хүүхдийн хууль зүйн хороо”, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлаар “Хамтарсан баг” ажиллахаар заасан боловч хэрэгжилт нь хангалтгүй, хүүхдийн эсрэг, хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хохирох, хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, хаягдах, төөрөх, архидан согтуурах, мансуурах, цахим тоглоомд донтох, биеэ үнэлэх, гал түймэр, гол усны аюул, ахуйн осолд өртөх зэрэг олон асуудлын улмаас амь нас, эрүүл мэнд нь хохирсоор байгаа нь улсын хэмжээнд тулгамдаж буй асуудал юм.

Хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирсон эсхүл гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрт хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагад хандаж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх ямар тусламж үйлчилгээ шаардлагатайг тогтоолгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж, эрхийг нь хангадаг байх хэрэгтэй.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хууль ёсны төлөөлөгч томилуулж оролцуулах, өмгөөлөгч /*ихэнх тохиолдолд төлбөрийн чадваргүй байдаг*/ ийг, сонгон авах, үйл ажиллагаа хүндрэлтэй. Амралтын өдөр, эсхүл шөнийн цагаар үнэ төлбөргүй өмгөөлөл, хууль зүйн туслалцаа өгч, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох асуудлыг Хууль зүйн туслалцааны төвөөс, хууль ёсны төлөөлөгч оролцуулах асуудлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас, зохион байгуулж, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь хэргийг бүрэн нотлох, шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой боловч дийлэнх тохиолдолд шөнийн болон ажлын бус цагаар явуулж буй мөрдөн шалгах ажиллагаанд дурдсан байгууллагын төлөөллийг оролцуулах ажиллагаа хангалттай бус байна. Нөгөө талаар гэмт хэргийн халдлагад өртсөн хохирогчдын нээлттэй чөлөөтэй ярилцах, хууль зүйн туслалцаа авах оролцогч нь өмгөөлөгч тул энэ чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгчдийг бэлтгэх, өмгөөллийн төлбөрийг үл харгалзан оролцуулдаг болгох тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Болдбаатар Ж. Криминалистик тактик. УБ. 2001.
2. Бүжинлхам Ц. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Тусгай анги. УБ. 2007.
3. Ганбаатар Г. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдсон гэмт хэргийг мөрдөх арга зүй. УБ. 2019.
4. Хурцгэрэл Б. Криминалистик 2. Сурах бичиг. УБ. 2004.
5. Хурцгэрэл Ж., Эрдэнэбат Б. Сонгуулийн үед ажиллах цагдаагийн алба хаагчийн үүрэг гүцэтгэх үеийн тактик, арга зүй, аюулгүй ажиллагаа. УБ. 2020.
6. Гэмт хэрэг илрүүлэхүй. /Хууль сахиулах их сургууль/. Сурах бичиг. УБ. 2015.
7. Цагдаагийн албаны хамтын бүтээл. Криминалистикийн тактик. УБ. 2001.
8. Эрдэнэбат Б. Мөрдөгчийн гарын авлага. УБ. 2019.
9. Эрдэнэбат Б. Өсвөр насны этгээдийн холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлог. Цагдаа судлал сэтгүүл. 2019.
10. Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ. 2016. №7.
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2017. №23.